# МОНГОЛ УЛС
# ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
# ЗАХИРАМЖ

2019 оны 02 сарын 19 өдөр Дугаар А/84 Хэрлэн сум

Газар эзэмшүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.3, 30 дугаар зүйлийн 30 1.5 дахь заалт, Захиргааны ерөнхий хуулийн 49 дүгээр зүйлийн 49.3.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Шунхлай трейдинг төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын тогтоолын 2018 оны 5 дугаар сарын 09-ний өдрийн Т-05 тоот тогтоол дагуу "Шунхлай трейдинг" ХХК-ий нэрийг "Шунхлай говь" ХХК болж өөрчлөгдсөн тул Хэрлэн сум 2 дугаар баг Баатруудын гудамж 1395м$^2$ газрыг эзэмшүүлсүгэй.

2. "Шунхлай говь" ХХК-ий эзэмшиж буй газрын кадастрын зураглалыг хавсралтаар баталсугай.

3. Газар эзэмших эрхийн гэрчилгээг олгон гэрээ байгуулж, гэрээний биелэлтэд байнгын хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Д.Баярхүү/-т үүрэг болгосугай.

4. Газар эзэмших гэрээнд тусгагдсан зориулалт, нөхцөлийн дагуу газраа эзэмшин, гэрээний биелэлтийг жил бүр дүгнүүлж байхыг "Шунхлай говь" ХХК-ий гүйцэтгэх захирал /Ж.Мөнхнаран/-т үүрэг болгосугай.

5. Энэхүү захирамжийг гаргасантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2018 оны А/316 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА Н.ГАНБЯМБА

D:\My Documents\Захирамж 2019.doc

01 235